

## **МОНГОЛ УЛС, ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХӨГЖИЛ ДЭХ ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХҮЧИН ЗҮЙЛ**

*Р.Жамц\**

### 1. Европын Холбоо байгуулагдсан ба Монгол Улс, Европын Холбооны хамтын ажиллагааны эхлэл тавигдсан нь

Монгол Улс, ХБНГУ-ын өнөөгийн харилцаа, хамтын ажиллагааны асуудлыг цогцолбороор авч үзэхдээ Монгол-Европын Холбооны харилцаатай нягтаар холбон судлах нь зүйтэй юм. Өнөө үед Европын орнууд ЕХ-ны хүрээнд интеграцчилагдах үйл явцад гүнзгий орж байна. Дундад зууны үеэс үүсэлтэй Европын нэгдлийн үзэл санаа дэлхийн II дайны дараа эрчээ авч, 1947, 1949 онд Бенилюкс-ын гэрээ, 1951 онд Европын нүүрс, гангын нийгэмлэг, 1957 онд байгуулагдсан Европын Атомын эрчим хүчний нийгэмлэг, Европын эдийн засгийн хамтын нийгэмлэг зэрэг нь 1992 онд Европын Холбоо байгуулахад нэгэн чухал түлхэц болсон юм.

2002 оныг хүртэл уг холбоонд Европын 15 орон багтаж байсан бол 2004 оноос энэ эгнээ өсч эдүгээ 25 орон болоод байна. Өнөө үед энэхүү асар том бүтэц 374 сая хүн амтай, нэг хүнд ногдох үндэсний нийт бүтээлдэхүүний дундаж нь 20000 ам.долларт хүрч худалдааны нийт эргэлтээрээ дэлхийд 2-р байранд ордог, дэлхийн нийт үйлдвэрлэлийн 19,8%-ийг 2000 онд үйлдвэрлэсэн нь 20,4%-ийг үйлдвэрлэдэг АНУ-ын дараа хоёрдугаарт орж байна.

Европын Холбоог байгуулах тухай Масрихтийн 1992 оны гэрээний дагуу Европын Холбоо нь нэгдсэн гадаад бодлого, аюулгүй байдал, нэгдсэн зах зээл, валютын бодлогыг хэрэгжүүлж эхэлсэн нь Европын Холбоо дэлхийн эдийн засагт төдийгүй улс төрийн амьдралд нөлөө үзүүлж чадахуйц томоохон хүчин болохыг харуулж байна.

2004 онд ЕХ нэгдсэн үндсэн хуультай боллоо. Тус холбоог байгуулах, бэхжүүлэхэд ХБНГУ чухал үүрэг гүйцэтгэсэн юм. ЕХ нь шинэ гишүүнээр эгнээгээ тэлж, дотоодын интеграцчилалыг гүнзгийрүүлж, мөн өөрийн байр суурийг улам бэхжүүлэх боллоо. Дэлхийд эзэлж буй байр суурь, гүйцэтгэж буй үүрэг нь улам бүр өсөн нэмэгдэж байгаа Европын Холбоотой Монгол Улс харилцаа, хамтын ажиллагаа эрчимтэй хөгжүүлэх нь манай орны хувьд гадаад бодлогын чухал чиглэлийн нэг болж байна. 1980-аад оноос эхэлж бий болсон гадаад, дотоод таатай нөхцөл нь

\* Р.Жамц - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор (Sc.D)

Монгол Улс 1989 оны 8-р сард ЕЭЗХН-тэй дипломат харилцаа тогтоох бололцоо олгожээ. ЕЭЗХН-тэй дипломат харилцаа тогтоохоос өмнө Монгол Улсын экспорт, импортын нэгдлүүд нийтийн зах зээлийн гишүүн зарим улс оронтой, тухайлбал Англи, Франц, ХБНГУ, Итали, Бельги, Австри зэрэг орнуудтай 1960-аад оноос худалдаа хийж эхэлсэн нь харилцааг хөгжүүлэхэд таатай нөхцөл болсон бөгөөд эдгээрийн дотроос Монгол Улс, ХБНГУ-ын худалдаа тэргүүн байр эзэлсэн билээ.

Монгол Улс, Европын Холбооны харилцаа, хамтын ажиллагаа 1989 оноос хойш улс төр, эдийн засаг, хөгжлийн тусламж гэсэн 3 чиглэлээр хөгжих боллоо. Дипломат харилцаа тогтоосноос хойш Монгол Улс 1992 оноос Европын Холбооны төв Брюссель хотноо элчин сайдын яамаа нээн ажиллуулж байна. Европын Холбооны Бээжин дэх элчин сайд манай улсыг хавсран ажиладаг бөгөөд Европын Холбооноос Монгол Улсад суух элчин сайд Эндимин Вилкинсон 1995 онд Итгэмжлэх жуух бичиг барьжээ.

Эдүгээ Европын Холбооноос Монгол Улсад суух Элчин сайдаар ноён Клаус Эберман 2001 оны 9 сараас эхэлж томилогдон ажиллаж байна. 2002 оноос Европын Холбооны Бээжин дэх Суурин төлөөлөгчийн газар Монгол Улстай харилцах асуудлыг дагнан эрхлэх ажилтныг томилон ажилуулж байна.

Монгол Улс, ЕХ-ы улс төр, эдийн засгийн харилцаа өргөжиж эрх зүйн үндэс бэхжиж байна. Харилцан хийсэн айлчлалуудын дотор:

- 1992 онд Ерөнхий сайд Д.Бямбасүрэн Европын Холбоонд
- 1992 онд Европын Холбооны комиссар Андриессен Монгол Улсад
- 1993 онд УИХ-ын дарга Н.Багабанди Европарламентад
- 1995 онд Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат Европын Холбоонд
- 1996 онд Европын Холбооны комиссар Ван Ден Брук Засгийн газрын урилгаар Монголд
- 1996 онд УИХ-ын дарга Р.Гончигдорж Европарламентад
- 2000 оны 1-р сард Ерөнхий сайд Н.Энхбаяр Европын Холбоонд
- 2000 оны 2-р сард Гадаад харилцааны сайд Н.Туяа Европын Холбоонд
- 2002 оны 7-р сард Европын парламент дахь Төв Азийн орнууд болон Монголтой харилцах бүлгийн төлөөлөгчид Монголд
- 2002 оны 10-р сард УИХ-ын дарга С.Төмөр-Очир Европарламентад
- 2003 оны 9-р сард Европын Комиссын тусламж, хамтын ажиллагааны албаны хөгжил, хүмүүнлэгийн тусламж

хариуцсан комиссар П.Нильсон Монгол Улсад тус тус айлчилсан.

Энэхүү харилцааны эрх зүйн үндсэнд:

- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр 1992 онд
- Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн худалдаалах хэлэлцээр 1995 онд (1998 онд энэ хэлэлцээрийн хугацааг сунгасан)
- Европын хөрөнгө оруулалтын банктай хамтран ажиллах Ерөнхий хэлэлцээр 1997 онд
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны гишүүнээр 2000 онд элссэн

Монгол Улс нь дэлхийд тэргүүлэх хөгжилтэй өрнөдийн орнуудыг эгнээндээ нэгтгэдэг ЕЭЗХН-тэй 1989 оны 8-р сарын 1-нд тогтоосон дипломат харилцаан дээр үндэслэн харилцаагаа цаашид бодитойгоор хөгжүүлэх, түүний үр ашгийг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор “Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-т 1992 оны 6 сард гарын үсэг зурсан билээ. Энэ хэлэлцээр 2 талын харилцааны эрх зүйн үндсийг тодорхойлж өгсөн ач холбогдолтой юм. Уг хэлэлцээр 4 бүлэг, 16 зүйлтэй, 1993 оны 3 сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон байна. Хэлэлцээрийн гол зорилго нь 2 тал тус тусын эрх мэдлийн хүрээнд Европын Холбоо, Монгол Улсын аж үйлдвэр, ХАА-н хөгжлийг ахиулах, эдийн засгийн харилцаагаа өргөтгөн бэхжүүлэх, шинжлэх ухаан, технологийн харилцаагаа өргөтгөх, хангамжийн шинэ эх үүсвэр, шинэ зах зээл нээж бий болгох, эдийн засгаа хөгжүүлж амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд тус дэм болох явдал юм. Энэхүү зорилгыг биелүүлэхийн тулд хэлэлцэж тохирогч 2 тал эдийн засгийн хамтын ажиллагааг бүх талаар тухайлбал, дараах салбарт хөгжүүлэхээр тохирчээ. Үүнд:

- Аж үйлдвэр, уул уурхай
- Хөдөө аж ахуй, ой аж ахуй
- Шинжлэх ухаан технологи
- Байгаль орчны хамгаалал
- Аялал жуулчлалыг хөгжүүлэх
- Оюуны болон аж үйлдвэрийн өмч, стандарт
- Статистик зэрэг чиглэл болно

Дурьдсан зорилгыг хэрэгжүүлэхийн тулд 2 тал тус тусын хууль, эрх зүйн бодлогын хүрээнд харилцан ашигтай, ахиу хөрөнгө оруулалт хийхийг хөхиүлэн дэмжиж тус дөхөм үзүүлж байхаар тохиролцож байна.

## 2. Монгол Улс, Европын Холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа

ЕЭЗХН хөгжиж буй орнуудад үзүүлдэг тусламжийн хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улсыг дэмжихэд чиглэсэн санхүүгийн болон техникийн хамтын ажиллагаа өргөжүүлнэ” гэж заажээ. Хэлэлцээрийн дагуу ЕЭЗХН-ийн 1983 оны гаалийн нэгтгэсэн номенклатур дахь Монгол Улсаас гаралтай Хамтын Нийгэмлэгийн бүс нутагт чиглэгдсэн импортын барааны тоо, хэмжээний хязгаарлалтыг хүчингүй болгон хэлэлцэн тохирч 2 тал Монгол Улс ба ЕЭЗХН-ийн гаралтай нүүрс, гангын бус бүх төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдаалах нэн тааламжтай нөхцлийг харилцан үзүүлэхдээ зах зээлийн үнэ ханшийг баримтлаж, бараа гүйлгээний эхээр төлбөрийг тус тусын холбогдох хууль тогтоомжийн дагуу чөлөөт хөрвөдөг валютаар хийхээр болжээ.

Мөн уг хэлэлцээрийг хэрэгжүүлэх 1 гол механизм болж уг хэлэлцээрийн биелэлтийг хянаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах санал, санаачилга дэвшүүлж байх үүрэг бүхий Монгол Улс, Европын Холбооны хамтарсан хороо байгуулахаар шийдвэрлэсэн юм.

Монгол Улс, Европын Холбооны худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Хамтарсан хороо байгуулагдаж, анхны хуралдаанаа 1993 оны 6-р сард Улаанбаатар хотноо хийсэн. Дараагийн ээлжит 8-р хуралдааныг Брюссель хотноо 2004 оны сүүлээр зохион байгуулахаар ярилцсан байна.

Монгол, ЕХ-ны хамтын ажиллагааны хамтарсан хорооны дэргэд Худалдаа, хөрөнгө оруулалтыг дэмжих дэд хороо байдаг бөгөөд тус дэд хорооны Монголын хэсгийн даргаар ҮХЯ-ы Төрийн нарийн бичгийн дарга ажилладаг.

Манай улс ТАСИС хөтөлбөрөөс АПА хөтөлбөрт шилжсэнтэй холбогдуулан энэ оноос ЕК-ын Азийн газар зүйн чиглэлийн нэгжилд харьяалагдах болсон.

Европын Холбооны П.Нильсон АШСТО-ын олон улсын 5-р бага хуралд оролцох үеэрээ Ерөнхий сайд Н.Энхбаярын урилгаар Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Тэрээр Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхаж, Монгол Улсын Ерөнхий сайд Санхүү, эдийн засаг, Гадаад харилцаа, Хүнс хөдөө ахуйн сайд нартай уулзаж, хөдөө орон нутгийн аж байдал, хүмүүсийн амьдралтай танилцаж манай улсад хэрэгжүүлж байгаа ТАСИС-ын зарим төслийн хэрэгжилтийн явц байдалтай газар дээр нь танилцсан нь хоёр талын хамтын ажиллагаа, хөтөлбөр, төслүүдийн цаашдын чиг хандлагыг оновчтой тодорхойлоход чухал ач холбогдолтой болов.

Европын Холбооноос манай улсад үзүүлж буй тусламжаа АЛА, ТАСИС хөтөлбөрийн хүрээнд олгож байна. ЕХ Ази, Латин Америкийн орнуудад АЛА, Зүүн Европын орнуудад ФАРЕ, Африк тив, Карибын тэнгисийн орнуудад Европын хөгжлийн Фонд, ТУХН-ийн орнуудад болон Монгол Улсад зориулсан ТАСИС зэрэг техникийн туслалцааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

ЕЭЗХН-ийн Зөвлөлийн 1981 оны 2-р сарын 12-ны 442/81 тоот тогтоолоор Ламейнын гэрээнд оролцоогүй Ази, Латин Америкийн хөгжиж буй 34 оронд хөгжлийн тусламж үзүүлэх, эдийн засаг, санхүүгийн ажиллагааг хөгжүүлэх зорилгоор АЛА хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлжээ.

Уг тогтоолд хамтын нийгэмлэгээс АЛА хөтөлбөрийн хүрээнд туслам үзүүлэхдээ дараахь 3 зарчмыг үндэс болгохоор заажээ. Үүнд:

1. Буцалтгүй тусламжийг нэн буурай хөгжилтэй оронд хүн амын хүнсний хангамжийг сайжруулах зорилгоор олгох

2. Тодорхой төсөл хэрэгжүүлэхэд дутаж байгаа хөрөнгийг нийлүүлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

3. Зарим нэг онцгой тохиолдолд, тухайлбал байгалийн гамшгаар учирсан хохирлыг гэтлэн даван туулах туслалцаа үзүүлэх зэрэг болно  
ЕЭЗХН-ийн Зөвлөл 1989 онд АЛА хөтөлбөртөө 3 төрлийн нэмэлт оруулсан байна. Үүнд:

1. Тусламжийг нэн буурай амьдралтай хүмүүст хүргэх

2. Эдийн засгийн өсөх потенциалтай хүмүүст хүргэх

3. Тусламжийн 10%-ийг буюу тодорхой хэсгийг хүрээлэн буй орчныг хамгаалахад зориулах зэрэг болно.

АЛА хөтөлбөрийн хүрээнд буцалтгүй тусламжийг:

- хөдөө аж ахуй

- хүрээлэн буй орчин

- хүний хүчин зүйлийг хөгжүүлэх

- хүмүүнлэгийн болон яаралтай тусламжийн салбарт олгодог.

Харин санхүү эдийн засгийн хамтын ажиллагааг:

- эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн мэдлэгийг дамжуулах

- удирдлага, менежментийг сайжруулах

- боловсон хүчин бэлтгэх, технологи дамжуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих, техникийн туслалцаа үзүүлэх замаар үйлдвэрлэлийг дэмжих салбарт хөгжүүлэхээр заасан байдаг.

Европын Холбооны ТАСИС хөтөлбөр нь нэг талаасаа Монгол Улс ба ЗХУ задарсаны үндсэн дээр шинээр тусгаар тогтносон орнууд,

нөгөө талаас Европын Холбооны орнуудын хооронд зохистой, үр ашигтай улс төр эдийн засгийн түншлэлийн холбоог байгуулах зорилготой юм. Мөн улс төрийн ардчилал, эдийн засгийн хөгжил цэцэглэл бүхий нийгэм байгуулах гэсэн түнш орнуудын санаачлагыг дэмжих зорилготой.

ТАСИС энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд зах зээлийн эдийн засгийн тогтолцоо, ардчилсан нийгэм байгуулах шилжилтийн үйл явцыг дэмжих, ноухауг санхүүжүүлдэг байна.

Бусад орнуудтай харьцуулахад ТАСИС хөтөлбөр Монгол Улсад нилээд амжилттай хэрэгжиж үр дүн нь сайн байгааг харгалзан үзээд ЕХ манай улсад үзүүлэх ТАСИС хөтөлбөрийн тусламжийн хэмжээг байнга нэмсээр байна.

Манай улсад 1996-1997 онд уг хөтөлбөрийн тусламжийн хэмжээг 1.5 сая еврогоор, 1998-1999 онд дахин 1.5 сая еврогоор тус тус нэмэгдүүлсэн байна. 1994-1995 онд 8 сая евро, 1996-1997 онд 9.5 сая евро, 1998-1999 оны хугацаанд 11 сая еврог ТАСИС хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсад олгосон байна.

ЕХ-ы АЛА, ТАСИС хөтөлбөрийн хүрээнд 1992-2003 онд 55.2 сая еврогийн 90 гаруй төслийг Монгол Улсад амжилттай хэрэгжүүлж ирсэн.

Энэ тусламжийг дээд боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, үр тарианы үйлдвэрлэл, мал аж ахуй, хөдөөгийн бөөний худалдааны сүлжээ, мал эмнэлэг, жижиг дунд үйлдвэр, эрчим хүч “сэргээдэх эрчим хүч”, тээвэр, аялал жуулчлал, байгаль орчин, мэдээлэл технологи, стандарт, хэмжил зүй, чанар, статистик, гааль зэрэг салбарыг бэхжүүлэх, засгийн газрын бус байгууллагуудыг дэмжих хотуудын түншлэлийн чиглэлээр төслүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

ЕХ нь Ази, Латин Америкийн орнуудад зориулсан АЛА хөтөлбөрийн хүрээнд 1992-1993 онд мал эмнэлэгийн албадыг бэхжүүлэх, стандарчилал, хэмжил зүй, чанарын хяналтын удирдлагын салбарыг хөгжүүлэх, менежментийг хөгжүүлэх, зах зээл судлалын хүрээлэнг дэмжих, сургалт явуулахад нийтдээ 8 сая евро буюу 10 орчим сая ам.долларын өртөг бүхий төслүүдийг Монголд хэрэгжүүлсэн байна.

АЛА хөтөлбөрийн дээрх төслүүдийг 1991 онд Улаанбаатар хотноо зохион байгуулсан Хандивлагчдын анхдугаар зөвөлгөөний үед тохиролцож шийдвэрлэсэн боловч зарим төсөл тухайлбал “стандарчилал, хэмжил зүй, чанарын хяналтын удирдлагын салбарыг хөгжүүлэх” төсөл 1997 оны 10 сард эхэлж 2001 онд дууссан байна.

ТАСИС хөтөлбөрийг тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн орнуудад шилжилтийн үеийн эдийн засгийн өөрчлөлт, шинэчлэлтийг дэмжихэд техникийн туслалцааг буцалтгүй тусламжаар үзүүлэх зорилготойгоор ЕХ 1990 оноос санаачилсан байна.

Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнуудад зориулж байсан тусгай хөтөлбөр ТАСИС-т нэгдэж орох нь манай оронд илүү тохиромжтой гэж Засгийн газар 1993 оны 11 сард шийдвэрлэсний дагуу манай улс 1994 оны 1 сараас ТАСИС хөтөлбөрт нэгдэх болсон. 2004 оноос Монгол Улсыг ТАСИС хөтөлбөрийн хүрээллээс АЛА хөтөлбөрт шилжүүлэхээр тохирсон бөгөөд албан ёсны шийдвэр 2003 оны 2-р хагаст Европарламентаас гарсан.

ТАСИС хөтөлбөр төслийн хүрээнд гадаадын зөвлөх экспертүүд ажиллуулах, гадаад, дотоодын сургалт явуулах, танилцах аялал зохион байгуулах, тоног төхөрөөмж, сургалтын материал ирүүлэх, зарим тодорхой объектын хөрөнгө оруулалтын өмнөх судалгаа, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг үндсэн ажлуудыг хийдэг.

ТАСИС хөтөлбөрийн түншлэл орнуудад 1996-1999 оны хугацаанд хувиарилсан хөрөнгө, нэг хүнд ноогдох хэмжээнээс харахад Монгол Улсын 1 хүнд ноогдох тусламжийн хэмжээ 8.9 евро буюу 9.49 ам.доллар болж ТАСИС хөтөлбөрийн хүрээнд хамтран ажиллаж ирсэн өмнөх туршлагадаа тулгуурлан 2002-2003 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 6 сая еврогийн төсөл хэрэгжүүлэхээр Европын комиссоос шийдвэрлэсэн бөгөөд эдгээрийн зарим нь 2004 онд хэрэгжиж эхэлсэн юм.

Өнгөрсөн хугацаанд ТАСИС хөтөлбөрийн дагуу хэрэгжсэн төслүүдээс хийж гүйцэтгэсэн зарим томоохон ажлуудын дотор:

1. Улсын хэмжээнд хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг боловсруулах нийслэлийн 8 дүүрэг, бүх аймгуудын хөдөлмөр эрхлэлтийн албыг шинэ нөхцөлд бий болгох, тэдгээрийг холбосон мэдээллийн сүлжээг байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг нийлүүлэх, уг сүлжээг улсын хэмжээнд тогтвортой ажиллуулах, хөдөлмөр эрхлэлтийн албаны ажилтнуудыг давтан сургах сургалтын төв шинээр байгуулах ажлыг 1995 оноос эхлэн гүйцэтгэжээ.

2. Баянхонгор, Өвөрхангай аймгийн 3 сумын төвийн сургууль, эмнэлэгт салхи, нарны хосолсон цахилгаан үүсгүүр суурилуулах судалгааны ажил хийгдсэн. Баруун аймгуудын нилээд алслагдсан хэдэн сумын төвүүдийг эрчим хүчээр хангах 1 МВ хүчин чадалтай бага оврын усан цахилгаан станц байгуулах судалгаа хийгдсэн байна.

3. Удирдлагын академийг бэхжүүлэх, нийслэл, аймаг, зарим сумдын төр захиргааны байгууллагуудын 1250 албан хаагчдыг сургалт, давтан сургалтанд хамруулсан байна.

4. МУИС-ийн Эдийн зсгийн дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, МУИС-ийн удирдлагын тогтолцоог сайжруулах, бүтцийн өөрчлөлт хийх, сургуулийн стратегийн төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх орлогын нэмэлт эх үүсвэрийг бий болгох, хичээлүүдийн сургалтын хөтөлбөр боловсруулах, европ хэлний сургалтын төв байгуулах зэрэг үйл ажиллагаа явагдсан.

5. Замын-Үүдэд нефть бүтээгдэхүүн шилжүүлэн очих байгууламж байгуулах техник эдийн засгийн судалгааг шинэчлэх 2 тэрбум гаруй төгрөгийн Олон улсын стандартад нийцсэн тоног төхөөрөмжийг суурилуулна. Нийтдээ 5000 м<sup>3</sup> багтаамжтай нефтийн агуулах бүхий иж бүрэн байгууламжийг бүрэн хэмжээгээр 2002 оны 11-р сард ашиглалтанд өгч орон нутагт 15-20 ажлын байр шинээр бий болгохоор ажиллаж байна.

6. Хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэхэд зориулсан 250 орчим сая төгрөгний зээлийн сантай төслийг хэрэгжүүлж, Кредит Монгол нэртэй компанийг банк бус санхүүгийн бие даасан байгууллагын хэлбэрээр ажиллуулж байна. Энэ төсөлд нийт 11 аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлсэн 31 аж ахуйн нэгжүүд хамрагдаад байна.

7. Улаанбаатар хот, Дорноговь, Дархан-Уул, Архангай, Хөвсгөл, Баян-Өлгий, Төв зэрэг аймгуудын засаг даргын тамгын газрыг бэхжүүлэх зорилгоор Европын хотуудтай түншлэлийн харилцааг хөгжүүлэх төслүүдийг хэрэгжүүлж, хот байгуулалт, байгаль орчин, боловсрол, ХАА, ой мод, бүс нутгийн төлөвлөлт, мэдээллийн технологи эрчим хүч хэмнэх чиглэлээр тодорхой ажилууд хийгдэж байна.

8. Монгол Улсад аялал жуулчлал хөгжүүлэх бодлогын баримт бичиг, стратегийн төлөвлөгөө боловсруулах, хууль эрх зүйн орчин бий болгох орчинг салбаруудын удирдлагыг бэхжүүлэх, аялал жуулчлалын үйлчилгээний норматив, стандарт зэргийг бий болгох, үндэсний аялал жуулчлалын төвийг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, Хөвсгөл нуурын тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөөний загварыг боловсруулах зэрэг ажил хийгдсэн байна.

9. Их, дээд сургуулиудыг Европын их, дээд сургуулиудтай холбох чиглэлийн 20 төсөл, төрийн бус байгууллагуудыг дэмжих 13 төсөл тус тус амжилттай хэрэгжжээ.

Тус хөтөлбөрийн хүрээнд “Хөдөөгийн эдийн засгийн хөгжил”, “Хувийн секторыг дэмжих, эдийн засгийг хөгжүүлэх”, “Шилжилтийн үеийн нийгмийн үр дагаварыг шийдвэрлэх”-д туслалцаа үзүүлэх чиглэлээр 2002-2003 онд тодорхой төслүүдийг Монгол Улсад хэрэгжүүлэхээр холбогдох яриа хэлэлцээр хийгдсэний зарим нь 2004 онд эхэлсэн билээ. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд хөдөөгийн эдийн засгийг хөгжүүлэх асуудал нь ЕХ-ны ТАСИС хөтөлбөрөөс Монгол Улсад үзүүлж буй тусламжийн үндсэн гол чиглэл болсон юм.

Үр тарианы төслийн хэрэгжилтийн явцад үр тарианы үйлдвэрлэл, мал аж ахуйн салбарын хослуулан хөгжүүлэх нь Монголын ХАА-н салбарын үр ашигт бүхэлд нь ач холбогдолтой гэсэн дүгнэлтэнд хүрсэн юм.

Жижиг, дунд үйлдвэрлэлүүдэд зээл олгож буй “Кредит Монгол” банк бус санхүүгийн байгууллага нь зээлийн сан “өмнө нь 250.000 еврогийн зээлэх хөрөнгөтэйг” 2002 онд дахин 500.000 еврогоор нэмэгдүүлж, зээлийн үйл ажиллагааг хөдөө орон нутагт чиглүүлэн ажиллаж байна.

ТАСИС хөтөлбөрийн цаашдын үйл ажиллагааны хүрээнд мал эмнэлэгийн үйл ажиллагааг сайжруулах, ХАА гаралтай түүхийн эдийг боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүний нэр төрлийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн худагуудыг сэргээн засварлах, малчид фермэрүүдийн хоршооллын аж ахуйг хөгжүүлэх хөдөөгийн бөөний худалдааны сүлжээг байгуулах чиглэлээр 2 том төслийг 2003 оноос эхлэн хэрэгжүүлж асуудлыг Санхүү эдийн засгийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яамтай хамтран боловсруулж байна.

Энэ асуудлыг боловсруулахдаа ТАСИС-ийн төсвийн боломж хязгаарлагдмал, хэрэгцээ шаардлага асар их байгааг харгалзан бусад хандивлагчдын үзүүлж буй тусламжтай нягт уялдуулан зохицуулах, үйл ажиллагааны давхардал гаргахгүйн тулд 2-3 аймгийг сонгон авч ажиллах асуудлыг судалж байна. Ингэхдээ зөвхөн техникийн туслалцаагаар хязгаарлахгүй хөгжлийн хамтын ажиллагааны төслүүдийг хэрэгжүүлэх боломжийг анхааралтай судалж байна.

Монгол Улсын Засгийн газар, ЕХ-ы хооронд 1993 оны 11 сарын 12-нд байгуулсан санамж бичгээр ЕХ-ны ТАСИС хөтөлбөрийн Үндсэн зохицуулах товчоог мөн Монголд байгуулахаар тохиролцсон. Үндэсний зохицуулах товчоо нь Засгийн газраас томилогдсон ТАСИС хөтөлбөрийн үндсэн зохицуулагчид ажлаа тайлагнадаг байна. Мөн 2 талын худалдаа, эдийн засгийн харилцааг идэвхжүүлэх, түүний нөөцийг бүрдүүлэхэд чиглэсэн зарим тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Монгол

Улсаас Европын хөрөнгө оруулалтын банк /ЕХОБ/-нд санал болгосон Баруунтурууны УЛС-ын техник эдийн засгийн судалгааны үндэслэл боловсруулахад шаардагдах 200.000 орчим еврогийн хөрөнгийг ЕХ-оос гаргуулах хүсэлтийг 2003 оны 3-р сард тавьж шаргуу хөөцөлдсөний үр дүнд уг хөрөнгийг Европын комиссын Европын тусламжийн хамтын ажиллагааны хөтөлбөрөөс санхүүжүүлэх шийдвэр 5-р сард гарч судалгаа хийх гэрээг уг ондоо багтаан байгуулж судалгааны багийг 2004 оны эхний хагаст ирүүлжээр болсон байна.

1993-1994 онд анх удаа Монгол Улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн бөгөөд 3.8 сая еврогийн улаан буудайн гурилыг Олон улсын Улаан загалмайн хавирган сар нийгэмлэг НҮБ-ын хүнс хөдөө аж ахуйн байгууллагын шугамаар нийлүүлсэн байна.

Монгол оронд учирсан зудын гамшгийг арилгахад тусламж болгон 2000 онд 1.3 сая евро, 2001 онд 575.000 евро олгосон. Европын комиссын хүмүүнлэгийн байгууллагаас 2001 онд Монгол Улсад 2.9 сая еврогийн хүмүүнлэгийн тусламж үзүүлсэн юм.

Европын Комиссын хүмүүнлэгийн тусламжийн байгууллагаас Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн аймгуудад, Европын зарим төрийн бус байгууллагын тусалцаатайгаар Увс, Өвөрхангай, Архангай, Хөвсгөл зэрэг аймгуудын зудад нэрвэгдсэн айл өрхийн 2-3 сарын хүнсний хэрэгцээг хангахад хүрэлцэхүйц хэмжээний гурил, цагаан будаа, ургамалын тос болон дулаан хөнжил, газар тариалан эрхлэхэд шаардагдах багаж хэрэгсэл нийлүүлэх ажлыг 2000-2001 оны өвөл, хаврын улиралд хийгдсэн. Европын Комиссоос 2002, 2003 онд Монголд тохиолдсон байгалийн гамшгаас учирсан хохирол, бэршээлийг даван туулахад зориулж 1 сая еврогийн хүмүүнлэгийн тусламж олгосон байна.

Монгол-Германы харилцаа, хамтын ажиллагааны хөгжилд ЕХ-ны хүчин зүйл нөлөөлдгийг Монгол-ЕХ-ны худалдаа, хөрөнгө оруулалтын байдал тодорхой харуулж байна.

2003 оны гүйцэтгэлээр Монгол Улсын нийт бараа эргэлт 1385 сая ам.доллар байгаа нь 2002 оныхоос 14,2 хувиар өссөн байна. Үүнээс экспорт 600,2 сая ам.доллар, импорт 787,3 сая ам.доллар байна. ЕХ сүүлийн жилүүдийн дунджаар Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлтэд 7-10 орчим хувийг эзэлж байна.

2003 онд Монгол Улсаас ЕХ-той хийж буй худалдаа нилээд өссөн нь хоёр талын худалдааг өргөжүүлэх үйл ажиллагаа идэвхжиж байгааг харуулж байна. Хоёр талын гадаад худалдааны нийт эргэлт 1993 онд 46,8 сая ам.доллар байсан бол ЕХ-ны гишүүн орнуудтай хийсэн бараа

эргэлтийн хэмжээ 86,9 сая ам.доллар /үүнээс экспорт 32,3 сая ам.доллар, импорт 54,6 сая ам.доллар/. Энэхүү өсөлт нь манай улсаас Их Британи, Итали, Франц болон ялангуяа ХБНГУ-тай хийсэн худалдаа ихээхэн өссөнтэй холбоотой.

Монгол Улсад 2003 оны байдлаар 875 сая ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт, түүнчлэн газрын тосны салбарт 127 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн байна. Өнөөдөр манай улсад орсон шууд хөрөнгө оруулалтын 8 хувь нь ЕХ-ны гишүүн орнуудад ногдож байгаа юм. 2003 оны байдлаар ЕХ-ны хэмжээ нь хөрөнгө оруулалттай 205 компани бүртгэгдсэн бөгөөд нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь 48 сая ам.доллар болжээ. Дээрхи байдлаас харахад Монгол Улс, ХБНГУ, ЕХ-ны хоорондын худалдаа, хөрөнгө оруулалтын харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлэхийн тулд, ялангуяа Монголын тал идэвхи, санаачлагатай ажиллах шаардлагатай байгаа юм.

Сүүлийн жилүүдэд ЕХ, Монгол Улсын харилцаа улам өргөжиж байна. 2005 онд Монгол Улс, ЕХ-ны хооронд хийсэн хэлэлцээний дагуу манай улсын үндэсний аж үйлдвэрийн сүлжмэл эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүн зэрэг 7200 орчим төрлийн бүтээгдэхүүнийг ЕХ-ны зах зээлд гаалийн хөнгөлөлттэй нөхцлөөр оруулах шийдвэр гаргасан нь манай улсын үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэх экспортын бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтөд бодитой хувь нэмэр болох сайхан боломж нээж байна.